

ЭРДЭНЭ РЕСУРС УЛААН АЛТНЫ НЭЭЛТИЙГ ТЭЛЖ, 2022 ОНЫ ХАЙГУУЛЫН ХӨТӨЛБӨРИЙГ ТӨЛӨВЛӨЖ БАЙНА

27.39 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал агуулсан 2.22 г/т алтны агуулга бүхий 24 метрийг огтоллоо

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот

2022.01.26

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | MSE: ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Зүүн-Өмнөд Улаан алтны нээлтийн 2021 оны хайгуулын хөтөлбөрийн үр дүн болон 2022 онд Улаан талбайд төлөвлөсөн хайгуулын хөтөлбөрийн төлөвлөгөөг танилцуулахдаа таатай байна. Зүүн-Өмнөд Улаан нээлт нь Баян Хөндий алтны төслөөс баруун зүгт 300 метрт компанийн 100% эзэмшлийн Улаан тусгай зөвшөөрлийн талбайд байрладаг бөгөөд 2021 оны 3-р улиралд хэтийн төлөв бүхий алтны нээлт хэмээн тодорхойлсон.

Онцлох мэдээлэл

- Зүүн-Өмнөд Улаан талбайн алтны хүдэржилт нь 200*250 метрийн талбайд, 460 метрийн гүнд үргэлжилж байгаа бөгөөд хойд, баруун зүгт болон гүндээ нээлттэй.
 - Хэд хэдэн цооног 3 г/т алтны дундаж агуулга бүхий зузаан бүсүүд (30-75 метр)-ийг огтолсон.
 - 22 цооногийн тал нь алтны хүдэржилтээр төгссөн бөгөөд үүнд 22.0 г/т алтны агуулга бүхий 2 метр (UDH-17) интервал багтана.
- 2021 оны 4-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрөөр нээлтийн цооногоос баруун өмнөд зүгт 100 метрт алтны хүдэржилтийн зузаан эрдэсжилт огтолсон (UDH-10).
 - UDH-32: Цооногийн 79 метрээс эхлэн 2.03 г/т алтны агуулга бүхий 16 метр интервал агуулсан 1.13 г/т алтны дундаж агуулга бүхий 43 метр огтолсон.
 - UDH-29: Цооногийн 91 метрээс эхлэн 27.39 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулсан 2.22 г/т алтны дундаж агуулга бүхий 24 метр огтолсон.
- Улаан нээлт нь түүнтэй зэргэлдээ орших Баян Хөндий төсөлтэй ижил төстэй шинж чанаруудтай.
 - Цахиуржин, цагаан гялтгануураар хувирсан галт уулын өргөн хүрээнд алт агуулсан, хүчтэй цахиур±адуляр±гематит судал болон штокверк бүсээр тодорхойлогддог.
- Хөндий дүүргийн хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 1-р улиралд Улаан талбайн нарийвчилсан хайгуулын хөтөлбөрийг боловсруулж, эцэслэнэ.

- Улаан талбайн зүүн зүгт 1.5 км тренд болох Зүүн-Өмнөд Улаан талбайн тэлэлтийн боломж болон тусгай зөвшөөрлийн талбайн төв ба зүүн хэсгийг шалгана.
- Хар Морь исэлдсэн алтны нээлтийн 4-р улирлын өрөмдлөгийн үр дүнгүүдийг 1-р улирлын дундуур танилцуулахаар төлөвлөсөн.

Тодруулга

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч ба гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Улаан нээлт нь Хөндий Дүүрэгт томоохон хэмжээний, өндөр агуулга бүхий алтны нээлт хийх боломжтойг илэрхийлсээр байна. Сүүлийн өрөмдлөгийн хөтөлбөрөөр алтны хүдэржилтийн зузаан үе баруун тийш үргэлжилж байгааг тогтоосон нь тусгай зөвшөөрлийн талбайн өмнөд зүг дэх 1.5 км трендийн гадаргуун шинж чанартай төстэй.”

“Улаан тусгай зөвшөөрлийг эзэмших болсноор бид бага зардлаар хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлж, нээлт хийн, тусгай зөвшөөрлийн өөр өөр хэсэгт хоёр чухал хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон. Энэхүү үр дүнгүүд нь Хар Морь болон Баян Хөндий ордыг агуулсан Хөндий-Улаан хувирлын тренд нь хэдэн сая унцын нөөцтэй алтны орд бүхий томоохон хэмжээний алт агуулсан гидротермаль системийн нэг хэсэг байх боломжтой гэсэн бидний таамгийг дэмжиж байна.”

Өрөмдлөгийн хөтөлбөрийн хураангуй

2021 оны 12-р сард гүйцэтгэсэн Улаан өрөмдлөгийн хөтөлбөрийн зорилго нь оны эхээр илрүүлсэн Зүүн-Өмнөд Улаан нээлтийн алтны хүдэржилтийн хүрээг тодорхойлох, баруун зүгт тэлэх боломжтой эсэхийг шалгахад оршиж байв. Хөтөлбөрөөр 2,900 тууш метрийн 8 цооног өрөмдсөн. Цооногууд нь хоорондоо 25-100 метрийн зайтай, дундаж гүн нь 362 метрт байсан бөгөөд хөтөлбөрийг ойролцоогоор 5 га зорилтот талбайд гүйцэтгэсэн. Өрөмдлөгийн хөтөлбөрийн онцлох мэдээллийг Хүснэгт 1-т танилцуулсан бөгөөд талбайн план зураглал болон хөндлөн зүсэлттэй хэвлэлийн мэдээний хавсралтаас танилцана уу.

Хүснэгт 1: 2021 оны 4-р улирал, Улаан өрөмдлөгийн хөтөлбөрийн онцлох үр дүнгүүд

(Дунджаар 0.30 г/т алтны агуулгаас дээш интервалуудыг танилцуулав)

Цооног	м-ээс	м хүртэл	Интервал ⁽¹⁾	г/т алт
UDH-27	278	296	18	0.36
Түүнд	282	288	6	0.73
Түүнд	328	330	2	0.50
UDH-28	282	291	9	0.47
Ба	306	350 ⁽²⁾	44	0.41
Түүнд	325	350 ⁽²⁾	25	0.59
UDH-29	91	171	80	0.86
Түүнд	97	121	24	2.22

Цооног	м-ээс	м хүртэл	Интервал ⁽¹⁾	г/т алт
Түүнд	108	109	1	27.39
Ба	220	260	40	0.37
Ба	315	316	1	0.46
Ба	334	336	2	0.33
Ба	340	342	2	0.38
UDH-30	127	137	10	0.36
UDH-31	88	110	22	0.40
Ба	135	144	9	0.30
Ба	252	350 ⁽²⁾	98	0.81
Түүнд	272	286	14	1.60
түүнд	315	323	8	4.54
Түүнд	320	321	1	25.90
UDH-32	79	122	43	1.13
Түүнд	84	100	16	2.03
Ба	168	350 ⁽²⁾	182	0.32
Түүнд	170	198	28	0.81
UDH-33	84	86	2	0.32
Ба	145	148	3	0.50
Ба	202	244	42	0.30
Ба	342	350 ⁽²⁾	8	1.66
UDH-34	276	300	24	0.57
Ба	338	342	4	0.32

- Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропыг тодорхойлох боломжтой.
- Цооногийн төгсгөл

Урьд нь танилцуулж байсан онцлох интервалуудын мэдээлэл (Хүснэгт 2):

Хүснэгт 2: 2021 оны Улаан талбайн өрөмдлөгийн хөтөлбөрийн онцлох мэдээлэл (Урьд нь танилцуулсан)

Цооног	м-ээс	м хүртэл	Интервал ⁽¹⁾	г/т алт
UDH-10	92	350.2 ⁽²⁾	258.2	0.98
Түүнд	99	139	40	3.77
Түүнд	103	104	1	39.57
Түүнд	123	124	1	58.40
UDH-14	106	117	11	3.68
Түүнд	110	111	1	36.58
Ба	188	404.6 ⁽²⁾	216.6	1.07
Түүнд	192	245	53	3.55
Түүнд	192	226	34	5.43
Түүнд	202	207	5	19.58
Түүнд	208	209	1	16.75
UDH-15	97	461.3 ⁽²⁾	364.3	0.79
Түүнд	124	215	91	1.98
Түүнд	130	140	10	7.29

Цооног	м-ээс	м хүртэл	Интервал (1)	г/т алт
Түүнд	130	131	1	15.13
Түүнд	138	139	1	49.36
Түүнд	214	215	1	10.47
UDH-16	65	184	119	0.59
Түүнд	117	120	3	4.52
Түүнд	119	120	1	11.91
UDH-19	82	272	190	0.73
Түүнд	87	92	5	12.52
Түүнд	87	88	1	60.55
UDH-21	115	192	77	3.19
Түүнд	131	158	27	8.74
Түүнд	139	140	1	156.54
Түүнд	155	156	1	20.98
Ба	209	280	71	0.81
Түүнд	222	230	8	1.92
Түүнд	257	271	14	2.79
UDH-22	85	236.7	151.7	1.71
Түүнд	85	150	65	3.11
Түүнд	87	94	7	18.50
Түүнд	93	94	1	119.80

- Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропыг тодорхойлох боломжтой.
- Цооногийн төгсгөл

Зүүн-Өмнөд Улаан нээлтийн тухай

Өнөөг хүртэл гүйцэтгэсэн өрөмдлөгийн үр дүнд Зүүн-Өмнөд Улаан талбайд томоохон алтны нээлт илрүүлсэн. Хэд хэдэн цооногуудад 354 метр хүртэл алтны хүдэржилт илэрсэн бөгөөд дийлэнх нь хүдэржилтээр төгссөн, 200-250 метрийн талбайг хамарсан. Зүүн-Өмнөд Улаан талбайд огтолсон алтны хүдэржилт нь газрын гадаргаас ойролцоогоор 80 метрийн гүнээс эхлэх бөгөөд талбайн зүүн талд орших Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрөл дэх Баян Хөндий эпитеpmаль алтны ордыг агуулагч цагаан гялтгануурын хувиралтай лапилли туфтай ижил зузаалагт агуулагдаж байна. 156.5 г/т хүртэл алтны агуулга нь агуулагч структур болон тэжээгч бүсүүдтэй холбоотой кварц±гематитын судлууд, штокверк бүсүүдэд тохиолдоно. Өмнөд Улааны алтны хүдэржилт дэх нэвчүүлэх чадвар багатай, цахиуржсан үнслэг туф бүхий литологи нь хүдэр агуулсан уусмалыг хэсэгчлэн хязгаарласнаар хүдэржихэд илүү тохиромжтой томовтор мөхлөгтэй лапил туфуудыг хүдэр агуулагч чулуу болгосон гэж үзэж байна. Структурын хяналт нь баруун хойд чиглэлтэй төстэй, баруун өмнөд чиглэлтэй унасан судлууд нь алт агуулж байгаа бөгөөд захын структур ба/эсвэл тэжээгч сувгууд нь ихэвчлэн зүүн хойд ба хойд зүгт чиглэсэн. Алтны хүдэржилт нь голлон бага агуулгатай, мөн литологиор хэсэгчлэн хянагдсан байх ба илүү томовтор мөхлөгтэй лапилли туф-д хүдэржилт голчлон төвлөрсөн нь баруун хойд зүг рүү давхарга зүйн уналаар нарийн ширхэгтэй цахиуржсан үнслэг туф нь хүдрийн уусмалыг нэвчүүлэх чадвар сул байдагтай холбоотой.

Ерөнхийдөө хамгийн өндөр агуулгатай алтны хүдэржилт нь цахиуржилт, адуляр болон цагаан гялтгануурын хувирлыг зүсэх эпитеpmаль төрлийн зөв хэлбэргүй кварц-гематит, кварц-адуляр, кварц-цагаан гялтгануур, кварц-хлорит-магнетитийн судлуудад тохиолддог. Ихэнх тохиолдолд судлуудад нүдэнд үзэгдэх алт нарийн тархсан байв.

Улаан тусгай зөвшөөрлийн тухай

Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн геологи нь томоохон (3 км диаметр бүхий) гидротермаль хувирлын бүсээр тодорхойлогддог ба зүүн зүг рүү Баян Хөндий орд, Хар Морь ба Алтан Сум хэтийн төлөвт талбайг хамардаг Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд үргэлжилдэг. Улаан талбайн геологи нь филлийн буюу QSP (кварц-серицит-пирит)-ийн хувирал зонхилж байгаа нь зарим тохиолдолд үндсэн агуулагч чулуулгийн бүтцийг дарсан байдаг. Тусгай зөвшөөрлийн талбайд хэд хэдэн үлдэгдэл өргөн кварцын биетүүд ажиглагдсан бөгөөд галт уулын болон туфын нэгжүүд нь эрчимтэй, багаас өндөр температурт шаврын хувиралтай байдаг. Мөн алт, зэсийн аномаль хагархай брекч ба турмалин хавтангууд ажиглагдсан нь идэвхтэй интрузив орчныг илэрхийлдэг. Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь хайгуулын харьцангуй эхэн үе шатанд байгаа ч геологийн үзүүлэлтүүдээс харахад бага температурт эпитеpmаль алтны хүдэржилт (Баян Хөндий, Зүүн-Өмнөд Улаан, Хар Морь) илэрсэн өндөр температурт порфирийн интрузив үйл явдалд өртсөнийг илтгэдэг. Кварцын судлын бүтэц, шаварлаг найрлага нь Хөндий-Улаан системийг томоохон эпитеpmаль төрлийн алтны эрдэсжилтийн орчин байгааг илтгэдэг бөгөөд туфлаг литологи нь хүдэржилт агуулах тохиромжтой агуулагч гэж үздэг.

Эрдэнэ Ресурсийн техникийн баг 2016 оны эхээр Баян Хөндий ордын анхны өрөмдлөгүүдийг гүйцэтгэх явцад дээрх нээлтүүдийг хийсэн. 2021 онд нэмэлт хайгуулын судалгаагаар Зүүн-Өмнөд Улаан ба Хар Морь талбайд томоохон нээлтүүдийг хийсэн. Хөндий-Улаан хувирлын бүс нь хайгуул хийгдээгүй томоохон алт агуулагч гидротермаль системийн нэг хэсэг хэмээн таамаглаж байна.

Улаан тусгай зөвшөөрлийн талбай болон Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Хөндий-Улаан гидротермаль хувирлын бүсийг агуулан, 4,000 гаруй га талбайг хамран оршдог бөгөөд хувирлын бүс нь Улаанаас зүүн хойш чиглэн 10 км үргэлжилдэг. Энэхүү хувирлын тренд нь Баян Хөндий алтны ордыг агуулагч цагаан гялтгануур, серицитийн гадна бүс болон серицитийн хувирлын захаар хүрээлүүлсэн хүчтэй хоёрдогч цахиурын төв бүсийг агуулдаг. Энэхүү зүүн өмнөд трендийн дагуу хувирсан бүсэд Улаан, Баян Хөндий болон бусад эрдэсжсэн хэтийн төлөв бүхий талбай багтаж байгаа нь зүүн өмнөд трендийн хагарлын дагуу бүс нутгийн структурын тэлэлтийн тэгш бус байдал ба томоохон галт уул - плутоник төвтэй холбогддог. Хөндий-Улаан талбай дахь хэтийн төлөв бүхий болон зэргэлдээ орших бүсүүдийн эрдэсжилт, хувирлууд нь томоохон структурын дагуу давхцаж эсвэл сунаж эрдэсжсэн нуман шилжилт бүхий баялаг магмын арлын нуман хувиралтай уялддаг.

Өнөөдрийг хүртэл компани нь хувирлын өргөн бүсийг хамарсан гадаргуун нарийвчилсан зураглал, геохимийн дээжлэлт, геофизикийн хөтөлбөрүүдийг гүйцэтгэсэн. Эрдэнэ Ресурс нь дээр дурдсан Зүүн-Өмнөд Улаан талбайд хийсэн таван га талбайд хийсэн өрөмдлөгөөс гадна тусгай зөвшөөрлийн 1,780 га талбайн төв болон зүүн хэсэгт нийт 1,846 метрийн 9 цооног өргөн зайтай өрөмдсөн. Компани нь 2022 оны дэлгэрэнгүй хайгуулын хөтөлбөрийг боловсруулахаар хайгуулын үр дүнгүүдийг техникийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар судлан ажиллаж байна.

Хөндий алтны дүүрэг

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардаг Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

Баян Хөндийд 2.19 г/т дундаж алтны агуулга бүхий 585,100 унц баттай болон бодитой геологийн нөөц¹ (“Measured and Indicated Resources”)², 2.18 г/т алтны агуулга бүхий 35,900 унц боломжит нөөц (“Inferred Resources”)³ тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7 г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтдаг. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

2020 оны 7-р сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Нарийвчилсан ТЭЗҮ-ийн суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон. Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ нь 0-7 жилийн хугацаанд 3.71 г/т алтны дундаж агуулга бүхий, жилд 63,500 унц алт олборлохоор тооцоолсон бөгөөд уламжлалт нүүрстэй уусгах технологиор боловсруулахаар төлөвлөсөн. Төслийн төлөвлөгөөгөөр олборлолтыг 2023 онд эхлүүлнэ.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуулын 2, ашиглалтын 3 тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын

¹ Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2021 оны 8 сарын 16-нд танилцуулсан 2021 оны 2-р улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангийн хэвлэлийн мэдээгээс танилцана уу.

² Баттай & Бодитой геологийн нөөц: 2.39 г/т алтны агуулга бүхий 232,700 унц баттай, 2.08 г/т алтны агуулга бүхий 352,400 унц бодитой нөөц

³ Батлагдсан & Магадласан: 4.4 г/т алтны агуулга бүхий 165,000 унц батлагдсан, 3.4 г/т алтны агуулга бүхий 256,000 унц магадласан үйлдвэрлэлийн нөөц; Үйлдвэрлэлийн нөөцийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хөндий Алтны Төсөл NI 43-101 Техникийн Тайлан, Tetra Tech 2019 оны 12 сарын 4-нд SEDAR болон компанийн вебсайт дээрх мэдээлэлтэй танилцана уу.

бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс ("SGS") лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт ("QA/QC")-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмет спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 гр дээжний 75 микроноос бага байх 30 гр бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцагт үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн Улаанбаатар дахь Эс Жи Эс ("SGS") лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнэ Ресурсийн ложистикийн гэрээт Монруд ХХК гүйцэтгэдэг.

Тайлагнасан интервал нь бодит зузаан бөгөөд өөрөөр хэлбэл цооногийн өргөн юм. Улаан талбайн өрөмдлөгийн цооногуудыг 85 градусын уналаар өрөмдсөн ба алт агуулсан судлын баруун-хойд баруун трендийн дагуу баруун урд уналын дагуу чиглэсэн. Бодит өргөнийг баталгаажуулахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Интервалуудын тайлагнасан агуулга нь түүвэр интервалын уртад үндэслэсэн жигнэсэн дундаж үзүүлэлтүүд юм. Дээд хязгаарлалт хийгээгүй боловч

10 г/т алтны агуулгаас өндөр агуулга бүхий интервалыг тодруулахаар тусад нь тайлагнадаг.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>


THE ULAAN SOUTHEAST GOLD DISCOVERY

The Khundii Gold District

Khundii – Ulaan Tenements, Bayan Khundii Gold Deposit and Prospects Location Map

Khundii – Ulaan Active Discoveries and Prospects


Khundii – Ulaan Hydrothermal Alteration Footprint



THE ULAAN SOUTHEAST GOLD DISCOVERY

300 Metres West of the Bayan Khundii Deposit

Ulaan Southeast Gold Discovery – West Targets




ULAAN SOUTHEAST PROJECT AREA PLAN MAP

Multiple Drill Holes Returned Over 100 metres of Gold Mineralization

Mineralization traced over a 200 by 250 metre area that remains open

Q4 2021 Drill Results (Red Collars)

Hole	From	To	Interval	Gold g/t
UDH-27	278	296	18	0.36
Incl	282	288	6	0.73
And	328	330	2	0.5
UDH-28	282	291	9	0.47
And	306	350	44	0.41
Incl	325	350	25	0.59
UDH-29	91	171	80	0.86
Incl	97	121	24	2.22
Incl	108	109	1	27.39
And	220	260	40	0.37
UDH-30	127	137	10	0.36
UDH-31	88	110	22	0.4
and	135	144	9	0.3
And	252	350	98	0.81
Incl	272	286	14	1.6
Incl	315	323	8	4.54
Incl	320	321	1	25.9
UDH-32	79	122	43	1.13
Incl	84	100	16	2.03
And	168	350	182	0.32
Incl	170	198	28	0.81
UDH-33	145	148	3	0.5
And	202	244	42	0.3
And	342	350	8	1.66
UDH-34	276	300	24	0.57
And	338	342	4	0.32




ULAAN SOUTHEAST GOLD DISCOVERY - DRILL SECTION A

Multiple holes returned 30 – 75m of over 3g/t gold within wide mineralized envelopes

Over half of drill holes ended in gold mineralization

Looking NW



Interpolated Gold Grade Shells and Interval Highlights